



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/61

Алтай хот

┌ Хамтарсан баг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуудан олгох болсонтой холбогдуулан мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж, шийдвэрлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хамтарсан багийн ахлагч:	Д.Баттайван	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Гишүүдэд:	Л.Ариунтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Энхзаяа	(Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч)
	Б.Дэлгэрмаа	(Татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)
	Р.Мөнхбаатар	(Авто тээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн)
	Н.Янжиндолгор	(Нийгмийн даатгалын хэлтсийн орлого, шимтгэлийн байцаагч)
	Г.Бурмаа	(Статистикийн хэлтсийн хүн ам хариуцсан мэргэжилтэн)
	С.Жавхлантуяа	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын статистик хариуцсан мэргэжилтэн)

᠒᠐᠑1000211

2.


(Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга: Б.Дэлгэрсайхан (Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Нийгмийн
халамжийн хэлтсийн дарга)

2.Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийн зөрүүг үнэн зөв болгох, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зорилтот бүлэгт хүргэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын тамгын газарт 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Хамтарсан багийн ахлагч (Д.Баттайван)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР